

## МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН ЧИГ БАРИМЖААГ СУДАЛСАН НЬ

*Н.Цогзолмаа, доктор, МУБИС,*

**Abstract:** Choosing a right profession is the beginning of one's happy life. How do people consider the value of choosing a profession in the past, now and the future? Nowadays, an era of globalization, it has become the crucial issue that to help our younger generations on choosing right profession and providing them with necessary information. Because we are requiring our younger generations to have skills and knowledge in order to achieve success not only in own country but also at global level. Choosing the right profession which is suitable for one's own needs, features and uniqueness and being satisfied with job and life can be a guarantee of consistent development for individuals and the country.

**Түлхүүр үг:** сонирхол хэрэгцээ, сэтгэлзүйн ялгаатай байдал, төрмөл чадвар, хөгжсөн чадвар

### Удиртгал

Мэргэжил сонголтын асуудлыг Монгол улсын Засгийн газар, БСШУЯ болон багш, эцэг эх, асран хамгаалагчид төдийлөн анхаарлаа хандуулдаггүй хэмээн судалгаанд хамрагдагчдын 60-80% нь үзсэн байна. Мэргэжлээ зөв сонгох нь хувь хүн, айл өрх болон албан байгууллага, салбар, улсын хөгжилд эерэгээр нөлөөлөхүйц чухал асуудал билээ.

2016-2017 оны хичээлийн жилд ахлах ангийн цөм хөтөлбөрийн хүрээнд “Мэргэжил сонголт” гэсэн 2 кредитийн багтаамж бүхий сургуулийн мэдлийн цагтай болж байгаа нь сайшаалтай хэрэг гэдгийг хэлэх нь зүйтэй юм.

Манай орны хувьд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонгоход туслах, дэмжлэг үзүүлэх асуудал нь эхлэл төдий байна. Харин төрийн бус байгууллага энэ чиглэлээр судалгааны ажил хийж мэргэжлээ зөв сонгосны ач тус, буруу сонгосны хор холбогдол зэргээр гарын авлага гаргаж тодорхой хугацаанд сургалт зохион байгуулж байгааг дурьдах нь зүйтэй байх.

Европын ихэнх оронд тухайлбал, Франц, Голланд, Шотланд, Англи, Швед, Финлянд, Норвеги, Дани зэрэг орнуудад 7 дугаар ангиас эхлэн мэргэжил сонголтоо хийдэг байна (Тунгалаг, 2008). Японд бага ангиас эхлэн мэргэжил сонгох асуудалтай холбоотой хичээлээс сонгож үздэг байна.

### Үндсэн хэсэг

Аливаа хүн өөрийн сонирхсон мэргэжилээ эзэмшиж, түүнийхээ үр шимээр амьдрах нь хүний амьдралын насан туршийн баталгаа болж аз жаргалтай, амар тайван сайхан амьдрах боломжийг бүрдүүлж байдаг.

Хэрвээ хүн 65-70 жил амьдарна гэж үзвэл бараг 40 жилийг өөрийн сонгосон мэргэжлээр ажиллаж өнгөрүүлдэг байна. Эндээс мэргэжил сонголт нь хүний амьдралын хамгийн чухал үнэт зүйл гэдэг нь харагдаж байна.

Энэ хорвоод ХҮН болж мэндэлсэн нь үнэт зүйл. Энэ үнэт зүйлээ улам үнэтэй болгоход 3 сонголт байдаг гэж бид үздэг.

1. Мэргэжил сонголт
2. Ажил сонголт
3. Хань сонголт

Эдгээр 3 сонголт нь харилцан бие биеэ уялдуулж байж амжилт гаргахад чухал нөлөө үзүүлнэ. Үүнээс зөвхөн мэргэжил сонголтыг авч үзсэн болно.

Мэргэжлээ сонгоход олон хүчин зүйл нөлөөлөх боловч хамгийн чухал нь өөрийгөө таних, судлах, өөрийнхөө хэрэгцээ сонирхлыг мэдэрч, өөрөөр хэлбэл өөрийнхөө сэтгэцийн онцлог, ялгаатай байдал, төрмөл авьяасдаа тулгуурлан мэргэжлээ сонгох нь өөрийн үнэлэмжийг дээшлүүлж буй хэрэг юм. Тиймээс мэргэжлээ сонгох гэж байгаа хэн бүхэн дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

### Үүнд:

- I. “Би”-гээ мэдэж сонголт хийх
  - a) Би хэн бэ?
  - b) Би ямар темпераменттэй вэ?
  - c) Миний хүсэл мөрөөдөл юу вэ?
  - d) Надад ямар мэргэжил тохирох бэ?
  - e) Надад ямар боломж байна вэ? гэх зэргээр хүүхэд өөрийнхөө бодит байдалд буюу “би”-д тулгуурлах
- II. Мэргэжлийн талаарх мэдлэг, мэргэжилтэй танилцах
  - a) Мэргэжил гэж юу вэ?
  - b) Мэргэжил сонголтоо хэдийнээс хийх вэ?
  - c) Мэргэжлийн онцлогтой танилцах
  - d) Энэ чиглэлээр цаашид ажиллах, бүтээмжтэй ажиллах боломжоо тооцож үзэх
  - e) Сонирхсон мэргэжлийнхээ дагуу судалгаа хийх, тухайн албан газартай танилцах, хамтран ажиллаж үзэх

Суралцагч өөрийн сонирхсон, хүссэн мэргэжлийн талаар мэдлэгтэй байх, судлан шинжлэх, эрэл хайгуул хийх, зочин төлөөлөгч болон албан газар, байгууллагатай хамтран ажиллах, харилцан ярилцах нь мэргэжлийн чиг баримжаа олоход ихээхэн тустай.

Бид энэхүү өгүүлэлдээ мэргэжил сонголтын талаар гурван өөр газар гурван өөр боловсролын түвшингээс авсан судалгааг танилцуулж байна.

**Судалгаа 1.** МУБИС, Газарзүй, Байгаль шинжлэлийн багшийн IV ангийн оюутан-багш Ч.Нямдоржийн Архангай аймгийн Төвшрүүлэх сумын сурагчдаас Мэргэжил сонголтын талаар хийсэн судалгаа (Нямдорж, 2015)

**Судалгаа 2.** МУБИС, Багшийн сургуулийн 1-р курсын оюутнуудаас мэргэжил сонголтын талаар хийсэн судалгаа

**Судалгаа 3.** Хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, судлаач, доктор Г.Тэгшбүрэнгийн мэргэжил сонголтын талаар хийсэн судалгааг <http://www.youtube.com> видео бичлэгээр авлаа (Тэгшбүрэн, 2015).

Судалгаа 1: Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдаас авсан судалгаа.

Сэдэв: ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтын чиг хандлагыг судалсан нь

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтын чиг хандлагыг судалж, түүний ололт, дутагдлыг илрүүлэн цаашид хэрэгжүүлж болохуйц санааг хүргэхийг зорилго болгон 50 сурагч / эрэгтэй 24, эмэгтэй 26/ судалгаанд хамруулжээ.

1. Сурагчдын ирээдүйн мэргэжлээ сонгосон байдлыг судлахад 66.7 хувь нь баттай сонгосон, үлдсэн 33.3 хувь нь эргэлзэж байгаа болон сонгоогогүй гэсэн хариултыг өгчээ (график 1).

График 1а. Мэргэжлээ сонгосон байдал

График 1а




График 1б. Мэргэжил сонгоход харгалзан үзсэн хүчин зүйл

График 1б



Үүнээс үзэхэд 66.7% нь мэргэжлээ сонгосон гэж хариулсан боловч өөрөө өөртөө зориулж бус мэргэжлийн онцлог, их дээд сургууль, урамшуулал тэтгэлэг зэргийг харгалзан сонгосон болох нь харагдаж байна.

2. График 2. Мэргэжил сонголтыг өөрийн сонирхол хэрэгцээ, бие физиологийн онцлог, сэтгэлзүйн байдал, хэв шинжид тохируулан сонгосон эсэхийг судалж үзсэн байна.

График 2а




График 2б




График 2а-д мэргэжил сонголтыг хийхдээ өөрийн сонирхолын дагуу сонгосон гэж хариулсан боловч, график 2б-д бие хүний онцлогийг илрүүлэх мэргэжил сонголтын тест ажилласан байдал, өөрийн сонирхол хэрэгцээ, бие физиологийн онцлог, хэв шинжид тохируулан сонгосон уу? гэсэн асуултад хариулсан зэргээс дүгнэвэл 71,4% үгүй гэж хариулсан байгаа нь мэргэжил сонголт, түүнээс гарах ач тус, хор холбогдолын талаарх мэдээ мэдээлэл, мэдлэгийг олж аваагүй болох нь харагдаж байна.

Энэхүү судалгааг авсан оюутан багш Ч.Нямдорж дараах дүгнэлтийг хийжээ.

1. Сурагчид ирээдүйн мэргэжлээ сонгоходоо мэргэжлийн онцлог давуу байдлыг харгалзан үзэхээс гадна их, дээд сургууль, урамшуулалт тэтгэлэг зэрэг нийгмийн хүчин зүйлсийг илүү анхаарснаас мэргэжлээ буруу сонгоход хүрч байна.
2. Сурагчдын мэргэжил сонголтод тухайн элсэх их, дээд сургуулийн нэр хүнд, сургалтын орчин, эцэг, эх, багш нарын нөлөө багагүй байгаа нь сурагчид сонирхолгүй мэргэжлээрээ суралцах нөхцлийг бүрдүүлж байна.
3. Сурагчид өөрийн бие физиологи, сэтгэлзүйн онцлог авьяас чадварыг зөвхөн хувийн бодол, бусад хүмүүсийн хэлсэн хийсвэр байдлаар тухайн мэргэжилд тохируулан өнгөц тодорхойлдог байна. Энэ нь мэргэжлээ буруу сонгоход хүргэж буй нэг сул тал болно.
4. Сурагчид мэргэжлээ зөв сонгоход чиглэгдсэн бие хүний болон сэтгэлзүйн

онцлогийг илрүүлэх тестүүдээр өөрийгөө оношлох, давуу болон сул талаа мэдэж өөрт тохирох мэргэжлийг сонгож чадахгүй байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдав.


Энэхүү судалгаанаас үзэхэд мэргэжил сонголтод их, дээд сургуулийн нэр хүнд, сургуулийн орчин, тэтгэлэг, эцэг, эх ихээхэн нөлөөлж байгаа нь харагдаж байна.

#### Судалгаа 2

МУБИС, Багшийн сургуулийн 1-р курсын 220 оюутнаас бага боловсролын багшийн мэргэжил сонголтын талаар хийсэн судалгааг танилцуулж байна.

Судалгааг асуулгын арга, холландын сорил, фокус бүлгийн ярилцлага, кейсээр авлаа. Судалгаанд хамрагдсан 220 оюутны 5 нь эрэгтэй, 215 нь эмэгтэй оюутан байв.

1. Асуулгын аргаар бага боловсролын багш мэргэжил сонголтод нөлөөлсөн хүчин зүйлийг асуухад:
  - А. Өөрөө хүсэж сонгосон- 43 оюутан -19.5%
  - Б. Хэрэгцээтэй мэргэжил гэж үзсэн-44 оюутан -20%
  - В. МУБИС буюу улсын сургууль- 56 оюутан -25.4%
  - Г.Эцэг эх, гэр бүл хамаатан садан нөлөөлсөн-31 оюутан-14%
  - Д. Хуваарь таарсан /оноо/-41 оюутан-18.6%
  - Е.Тэтгэлэг-5 оюутан- 2.2%
  - Ё. Бусад –



Судалгаанаас үзэхэд 19.5% нь өөрийн хүсэлтээр, хэрэгцээтэй мэргэжил хэмээн сонгосон нь 20%-ийг эзэлж байна. Үүнээс зөвхөн өөрөө хүсэж тус сургуульд элсэн орсон гэж хариулсан оюутантай ярилцаж үзэхэд өөрийнхөө “би”-г мэдэж сонгосон уу? гэдэг нь эргэлзээтэй байлаа. Учир нь фокус бүлгийн ярилцлага хийхэд бага ангийн багшийнхаа талаар, манай ээж бага ангийн багш, өвөө сайн багш байсан, бага ангийн багш эрэлт хэрэгцээтэй мэргэжил гэх зэргээр

өөрийгөө биш, өөр хүчин зүйл, өөр хүнийг өөртөө төсөөлүүлэн ярьж байсан нь өөрийн сонголт мөн үү? гэсэн эргэлзээг түрүүлж байв. Мэргэжил сонголт нь нийгмийн хөгжлийн “гарц” хэрнээ иймэрхүү байдлаар мэргэжил сонголт хийж байна гэсэн үр дүн гарч байна.

Хүснэгт 1

Ж.Холландын бие хүний онцлог, мэргэжлийн хамаарлыг харуулсан тодорхойлолт

Бие хүний хэв шинж	Бие хүний чанарууд	Сонирхол	Төлөөлөх мэргэжлүүд	Хариулсан оюутны тоо /давхардсан/
1. Бодит үйл ажиллагааг эрхэмлэгч хэв шинж	Үнэнч, тууштай, ажил хэрэгч, буурь суурьтай, энгийн реалист	Гарын эв дүй сайн, механик, хөдөө аж ахуй, цахилгаан, техник, технологи	Ажилчин, машин, техникийн оператор, нисэгч, фермер, том тэрэгний жолооч, мужаан	59
2. Судалгаа шинжилгээний хэв шинж	Шинжлэн судлах, шүүмжлэх дуртай, сонниуч, ухаантай, интроверт буюу дотогш чиглэсэн байдалтай	Шинжлэх ухаан, математик	Физикч, хүн судлаач, химич, математикч, биологич	41
3. Уран сайхны хэв шинж	Сэтгэлийн хөдөлгөөн ихтэй, мөрөөдөмтгий, ургуулан бодох чадвар сайн, дэврүүн, бусдаас хамааралгүй, зөн билэг хөгжсөн	Хэл, урлаг, хөгжим, драм, зохиол бүтээл туурвих	Яруу найрагч, зохиолч, уран барималч, театр судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч	96
4. Нийгмийн хэв шинж	Бусадтай хамтран ажиллаж чаддаг, нөхөрсөг, тусч, яриа хүнийг ойлгодог	Харилцааны ур чадвартай, хүнтэй ажиллах болон боловсролын ажилд дуртай	Клиник сэтгэл зүйч, зөвлөгч, багш, эмч	106
5. Удирдах ажил хэрэгч хэв шинж	Адал явдалд орооцолддог, нэр хүнд албар тушаалд дуртай, эрч хүчтэй, өөдрөг үзэлтэй, өөртөө итгэлтэй, яриа	Манлайлал, харилцааны ур чадвар, хүнд нөлөөлөх чадвар	Менежер, худалдаачин, улс төрч, хуульч	133
6. Хэвшмэл Стандартыг баримтлагч хэв шинж /Conventional type/	Үнэнч шударга, бүтээлч, дуулгавартай, нямбай, өөрийгөө хянадаг	Бичиг хэрэг ба тооцооны ажил, бизнесийн тогтолцоонд ажиллах	Мөнгө хураагч, статистикч, данс бүртгэгч, захиргааны туслах ажилтан, шуудангийн ажил	89

Судалгаанаас үзэхэд:

Нийгмийн хэв шинжид-106 оюутан, Судалгаа шинжилгээний хэв шинжид-41, Уран сайхны хэв шинжид-96 оюутан, Төлөөлөх мэргэжил буюу физикч, хүн судлаач, химич, математикч, биологич, яруу найрагч, зохиолч, уран барималч, театр судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч мэргэжлүүдэд-137 оюутан хариулсан байгаа нь бага боловсролын багш мэргэжлийн онцлогтой

холбоотой байж болох юм.

Бага боловсролын багш мэргэжил нь бусад багш мэргэжлээс олон онцлог ялгаатай. Тухайлбал: Хүний хөгжлийн сэтгэл судлал, хүүхэд судлал, суралцахуй ба багшлахуй, заах арга, тусгай хэрэгцээт боловсрол, дуу хөгжим, биеийн тамир, дүрслэх урлаг, технологи, математик, монгол хэл, уран зохиол, хүн нийгэм, хүн байгаль, эрүүл мэнд, гадаад хэл, мэдээлэл харилцаа, түүх,

логик сэтгэлгээ, иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэх зэрэг олон шинжлэх ухааны үндэс бүхий хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар бага боловсролын багшид бэлтгэгддэг.

### Судалгаа 3

Хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, судлаач доктор Г.Тэгшбүрэн хүний нөөцийн менежерүүдээс мэргэжил сонголтын талаар судалгаа авсан байна. <http://www.youtube.com> видео бичлэгээс үзнэ үү.

Судалгаанд 400 менежер хамрагджээ.

Үүнээс:

- 5% буюу 20 хүн анхныхаа сонгосон мэргэжлээр суралцаж ажиллаж байна.
- 95% буюу 380 хүн анхныхаа сонгосон мэргэжлээрээ ажиллаагүй, мэргэжлээ буруу сонгосон ба өөр мэргэжлээр дахин сурсан гэсэн үг. Энэ 95%-ийн буруу сонголтыг авч үзэхэд 15% нь 25 насны залуучууд, 49,2% нь 25-35 насны залуус байсан. Эдгээр залуус нь байгууллагын гол ажил үүрэг гүйцэтгэж байх ёстой байтал ажлаа сольдог. Бас 25,8% буюу 35-45 насныхан бөгөөд 6-10 жил ажилласан, карьерын хувьд албан тушаал ахих, ажлын туршлага хуримтлуулсан байдаг хэдий ч ажлаа сольдог. 10% нь 45 дээш насныхан бөгөөд 2-3 удаа ажлаа сольсон байдаг тухай судалгаа гарчээ. Энэ бүхнийг дараах байдлаар дүгнэж болохоор байна.

1. Мэргэжил сонголтоо зөв хийгээгүй
2. Байгууллагад хүний нөөцийн тогтвор суурьшил байхгүйгээс бүтээмж муу, алдагдал ихтэй.
3. Байгууллагын ажилтаны карьер хөгжил, байгууллагын төлөвлөлт алдагддаг.
4. Тогтвор суурьшилгүй ажиллах нь ажилдаа амжилт бүтээл гаргахад сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлт хийж байна.

Дээрх гурван судалгаанаас үзэхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байх үеэс мэргэжлээ буруу сонгосон нь их, дээд сургуульд суралцах явцад “дарамт” болж төгссөний дараа тогтвор суурьшилтай ажиллах, амжилт гаргах, үр дүнгээ үзэхэд сөрөг нөлөөтэй болох нь харагдаж байна.

Мэргэжлээ зөв сонгосноор хувь хүн, айл өрх болон албан байгууллага, салбар, улс орны хөгжлийг тодорхойлох хүчин зүйл болдог.

Хүн дуртай зүйлээ хийж байхдаа хамгийн аз жаргалтай байдаг байна. Энэ үед сэтгэл санаа амар тайван инээмсэглэсэн, бодож сэтгэх нь илүү оновчтой бүтээлч, бүтээл нь чанартай, цаашид түгээн дэлгэрүүлэх, ашиг үр шимээ өгсөн, олны хүртээл болсон бүтээгдэхүүн гарч байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн цаг үеийн хэрэгцээг хангасан инноваци бий болдог байна. Энд энгийн нэгэн жишээг авч үзье. “Инээмсэглэн угтаж, инээмсэглэн үдье” гэсэн уриатай албан газар олон байдаг. Гэтэл тэр албан газарт мэргэжлээ буруу сонгосон хүн байж л таарна. Тэр хүнд худлаа инээх нь ямар хэцүү байдаг бол, инээх нь түүнд магадгүй “тулгалт” юм. Ер нь мэргэжлээ зөв сонгох нь хэрхэн, яаж суралцах, өөрийн улс орон бөгөөд дэлхийн түвшинд өөрийн мэдлэг, чадвараа харуулах боломж гэдгийг хүн бүр ойлгож, ухамсарлах хэрэгтэй болоод байна.

### ДҮГНЭЛТ

1. Судалгаанаас үзэхэд ерөнхий боловсролын сургуулийг төгсөх гэж буй суралцагчдын мэргэжил сонголт-71.4%, их, дээд сургуульд сонгосон мэргэжлээр суралцаж байгаа оюутан-60.2%, суралцсан мэргэжлээрээ ажиллаж байгаа хүмүүсийн 95% нь мэргэжлээ буруу сонгосон болох нь харагдаж байна. Энэ нь хувь хүн, айл өрхийн болоод албан байгууллага, салбар цаашлаад улсын хөгжилд сөрөг нөлөөтэй болох нь тодорхой юм.
2. Мэргэжил сонголтыг хийхдээ өөрийн хүсэж сонгосон мэргэжил гэж хариулсан боловч “би”-д буюу өөрийн сонирхол, хэрэгцээ, төрмөл авьяас чадвар, зан төлөв, сэтгэцийн онцлогт тохируулан сонгодоггүй бусдын амжилтыг өөртөө төлөөлүүлэн сонголтоо хийдэг болох нь харагдлаа. Тухайлбал: “Миний ээж багш учраас...”, “Миний өвөө бага ангийн сайн багш байсан гэж хүмүүс ярьдаг байсан. Тиймээс би багш болохоор шийдсэн.”, “Манай бага ангийн багш сайн багш байсан” гэх зэргээр хариулж байгаа нь өөрийн сонирхол мөн үү? гэсэн асуулт гарч ирж байгаа юм.
3. Дунд сургууль төгсөгчид их, дээд сургуулийн нэр хүнд, сургуулийн орчин, тэтгэлэг, эцэг, эхийн нөлөөллөөр мэргэжлээ сонгож байна.
4. Байгууллагад хүний нөөцийн тогтвор суурьшил байхгүйгээс бүтээмж муу, алдагдал ихтэй, байгууллагын ажилтаны

карьер хөгжил, байгууллагын төлөвлөлт алдагддаг, тогтвор сууршилгүй ажиллах нь ажилдаа амжилт бүтээл гаргахад сөргөөр нөлөөлдөг байна.

5. Мэргэжил сонголтод суралцагчийн /I курс/ төрмөл авьяас чадвар, сургалтын явцад хөгжсөн авьяас чадвар нөлөөлдөг гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, бага боловсролын багш мэргэжлээр суралцах явцад багш мэргэжлийн удиртгал, хүний хөгжлийн сэтгэл судлал, багшийн харилцаа хандлага зэрэг нь тэднийг багш болох хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлдэг байна.

Эцэст нь бидний хойш ирээдүй болсон хүүхэд залуучуудын мэргэжлийн чиг баримжаатай болоход, мэргэжил сонголтыг хийхэд үндэсний хэмжээний хүний нөөцийн бодлого хэрэгтэй болох нь харагдаж байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Гомбо, Д. (2014). *Мэргэжил сонгох тань*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг Групп
- Өлзийбаяр, В. (1999). *Ажил мэргэжлийн сэтгэл онцлогийг харгалзан удирдах нь*. Улаанбаатар
- Тунгалаг, П. (2008.10). ОХУ-д ахлах ангийн сурагчдын мэргэжлийн чиг баримжаатай болгож ирсэн туршлагаас. *Боловсрол судлал сэтгүүл*, 31(27)
- Hafeng, Liu., Qiong., Wu. (2009.6). Хятадын коллежийн элсэлтийн шалгалтын үр дагаврууд ба түүний шинэчлэлд гарч байгаа бэрхшээлүүд. *Боловсрол судлал сэтгүүл*, 62(3)
- Чойноров, С. (2013). *Мэргэжлээ зөв сонгох нь*. Улаанбаатар
- Dixie Somers Финляндад Ахлах ангийн хүүхэд мэргэжлээ сонгоход нь туслах 5 шилдэг арга (2013.11.18) АНУ <http://www.howtol-arn.com>. <http://careerplanning.about.com/-c> авав.
- Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ? 1.10.2010 нийтэлсэн нийлэлийг [www.leu.gov.mn-c](http://www.leu.gov.mn-c) авав.
- Хэрхэн өөртөө тохирох мэргэжил сонгох вэ? [www.tsahim.net/articles/education/612-how-to-choose-roght-career](http://www.tsahim.net/articles/education/612-how-to-choose-roght-career) -с татаж авав.
- Рюү Мураками. (2010). Япон Сайн байна уу? ажил мэргэжил минь <http://www.joblinksmn.com/>-с татаж авав
- Мэргэжил сонголт ТЕЛЭ нэвтрүүлэг. <https://www.youtube.com/>-с татаж авав.
- Ганбаатар, С. (2013.05.01). Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ? (<https://www.youtube.com>)